



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№94 /307/

2022.05.16

“ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, МАНЛАЙЛАЛ”-ЫН МЭРГЭШҮҮЛЭХ ЗОРИЛТОТ СУРГАЛТ ЯВАГДАЖ БАЙНА



Зэвсэгт хүчинд нэн шаардлагатай байгаа чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх, мэдлэг, үр чадварыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Батлан хамгаалахын сайдын санаачилсан “Хүний хөгжлийн менежер”, “Цэргийн сэтгэл зүйч”-ийг бэлтгэх сургалт ҮБХИС-ийн Нийгэм хүмүүнлэгийн тэнхимийг түшиглэн 3 сарын хугацаатай танхимаар явагдсан.

Тэгвэл энэ удаад цэргийн нэгтгэл, анги, байгууллагын бүх түвшний удирдах ажилтнууд, алба хаагч-хувь хүний хөгжил, манлайллын мэдлэг, чадварын шинэчлэл, хандлагын өөрчлөлтөд дэмжлэг үзүүлэх зорилготой “Хувь хүний хөгжил, манлайлал”-ын мэргэшүүлэх зорилтот сургалт мөн ҮБХИС-ийн Нийгэм хүмүүнлэгийн тэнхимийг түшиглэн 1 сарын хугацаатай явагдаж байна.

Батлан хамгаалахын сайдын ивээл дор үргэлжилж буй тус сургалтаар хүний хөгжлийн онол, арга зүйн шинэ программын дагуу хувь хүний хөгжлөөс баг, бүлгийн хөгжил, түүнээс цэргийн анги, байгууллага, Зэвсэгт хүчний байгуулалтын хөгжлийн хамаарлын талаарх мэдлэг, үр чадварыг суралцагчдад эзэмшүүлэх ажээ.

Нийгэм хүмүүнлэгийн тэнхимийн багш С.Мандалмаа энэ удаагийн сургалтын талаар хэлэхдээ “Одоо танхимд байгаа суралцагсад өмнөх сургалтад хамрагдсан бүрэлдэхүүнээс эзэмшсэн мэргэжил, хийж гүйцэтгэж буй ажлаараа ялгаатай. Хугацаат цэргийн алба хаагчдыг оюун санаа, сэтгэл зүйн тал дээр нь төлөвшүүлж, хөгжүүлж цаашид амьдралаа зөв төлөвлөхөд нь дэмжлэг үзүүлэхэд сургалтаас олж авсан мэдлэг, дадлага туршлага чухал нөлөөтэй. Суралцагсад маань бусдын хөгжих боломжийг бүрдүүлэхэд өөрөө

үлгэрлэх, бүтээлч байдлаар хандах, сэдэлжүүлэх зэрэг манлайллын цогц ойлголтуудыг судалж байна. Үүнийгээ ажил алба, өдөр тутмын үйл ажиллагаандаа бодитоор хэрэгжүүлэхэд чиглэснээрээ сургалт туйлын ач холбогдолтой” хэмээв.

Батлан хамгаалахын сайдын дэргэдэх Иргэний зөвлөл 7 чиг үүргийг хэрэгжүүлж байгаагийн нэг нь цэргийн алба хаагчдыг соён гэгээрүүлэх, зөөлөн чадварт суралцуулах, сэтгэлийн боловсрол олгох, тэр тусмаа захирагч дарга нарт зөвлөгөө өгөх, бодитой туслалцаа дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн дээрх сургалт юм.

Тэгвэл тус зөвлөлийн гишүүн ҮБХИС-ийн зөвлөх профессор, Гавьяат багш А.Гэлэгжамц “Батлан хамгаалахын сайдын дэргэдэх Иргэний зөвлөлийн зүгээс өмнөх сургалтуудад өндөр ач холбогдол өгсөн. Тиймээс энэ удаагийн сургалтад мөн онцгой анхаарч байгаа. “Хувь хүний хөгжил, манлайлал”-ын мэргэшүүлэх зорилтот сургалт хүнтэй нягт тулж ажилладаг салаа, салбарын офицеруудын түвшний хүмүүс хамрагдаж байна. Хичээлийн агуулгадаа хүний хөгжил, хувь хүний менежмент, стресс, эрх зүйн зохицуулалт, хүнтэй ажиллах арга барил, сэтгэл зүйн асуудал, ёс суртахууны асуудлыг, мөн өөрийгөө олох, бусдыг танин мэдэхэд дэмжлэг үзүүлэх талаар түлхүү тусгаж өгсөн. 180 цагийн цагийн багтаамжтай сургалтын хураангуй шахуу хуваарьтай сургалтын хөтөлбөр байгаа. Үүгээрээ өмнөх сургалтаас онцлогтой. Мөн сургалтын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор анги, салбарт хүрч очно гэсэн бодолтой байна. Манай багш

нараас ийм санал, санаачилга гарсан. Энэ хүрээнд модуль сургалтыг 3-5 хоногийн хугацаанд зөвлөгөө өгөх чиглэлээр зохион байгуулах хүсэлтээ тавиад байна. Яг газарт нь, тухайн анги, салбарын офицер, ахлагч, цэргүүдтэй уулзаж, хүнлэг байх, хүнийг чиглүүлдэг эрх зүй, ёс суртахууны асуудлаар, өөрийгөө олоход дэмжлэг үзүүлэх богино хугацааны зөвлөгөө хэлбэрийн сургалтыг явуулахаар төлөвлөн бэлтгэл ажлаа хангаж байна” гэж онцолсон.

Цаашид сургалтын чанар, үр өгөөжийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх, ач холбогдол, хүртээмжийг дээшлүүлэхэд дан ганц танхимд байгаа

сургалтад хамрагдаж байна. Түүний сэтгэгдлийг тодруулахад “Би Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийн барилга угсралт, засварын ротын ахлагчаар ажилладаг. Энэхүү сургалт маш үр өгөөжтэй. Хүн хоорондын харилцаа, хувь хүний хөгжил, төлөвшил, ёс суртахууны талаар өргөн цогц ойлголтыг аваад байна. Миний хувьд хугацаат цэргийн алба хаагчидтай тулж ажилладаг албан тушаалтан. Эцэг эхийнхээ гар дээрээс цэргийн албанд ирж байгаа залуустай харилцах, тэднийг цаашид ажил амьдралд нь хэрхэн чиглүүлэх, зөвлөх, тусалж дэмжихэд өөрийн үүрэг, оролцоог өндөр гэдгийг илүүтэй ухамсарлалаа. Үүнийгээ хэрхэн гүйцэтгэх талаар ч мэдлэг мэдээлэлтэй боллоо. Багш нарын арга барилаас гадна нэгэн дээвэр дор хамт суралцаж байгаагийн хувьд бид бие биеэсээ мөн чамгүй зүйлийг сурч мэдсэн. Нөлөөллийн ажил ч сайн хийгдэж байна. Энэхүү сургалт үнэхээр олон талын ач холбогдолтой гэж хэлэхэд болно” гэсэн юм.

Мөн Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн салааны захирагч дэслэгч Б.Баасандорж “Залуу хүн цаг ямагт сурч боловсрох хэрэгтэй. Үүнд ч өөрийг дайчлах нь зөв. Тэр бодолд хөтөлгөдөн энэ сургалтыг зорьж ирсэн. Сургалтаас олж авч байгаа мэдлэгийг ажил, албандаа нэвтрүүлж бүтээгдэхүүн болгоход энэ сургалтын үнэ цэн оршиж байгаа гэж бодож байна. 21 дүгээр зуун хөгжлийн эрин үе гэгддэг. Тэгэхээр Зэвсэгт хүчний офицер, ахлагч, хугацаат цэргүүд нийгэм, цаг үетэйгээ хөл нийлүүлж алхах нь нэн чухал. Удирдах бүрэлдэхүүний үүрэг ч өндөр, ялангуяа хугацаат цэргийн



бүрэлдэхүүний оролцоо хангалтгүй. Тийм учраас анги, байгууллагын шат шатны удирдлагуудын уялдаа, холбоог сайжруулах шаардлагатай гэдгийг багш нар хэлж байв.

Ахлах ахлагч Б.Ганзолбоо улсын баруун хязгаараас ирж энэхүү

алба хаагчдыг чиглүүлж, амьдралын үзэл санааг нь зөв төлөвшүүлэхэд. Энэ сургалтад хамрагдсандаа сэтгэгдэл өндөр байна. Ихийг сурч мэднэ ээ” гэлээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
19	0

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
38	27

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,116.00	3,125.0
EUR	3,275.0	3,305.0
CNY	458.00	463.00
RUB	40.80	42.00
JPY	24.50	24.80
KRW	2.42	2.46

ЗУРХАЙ



2022.05.16 /ЛХАГВА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 15

ЗУНЫ ТЭРГҮҮН ХӨХӨГЧИН МОГОЙ САРЫН ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ ШАРАГЧИН МОГОЙ ӨДӨР

Үс засуулбал:
Өлзийтэй сайн
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
05.13-20.24
Барилдлага:
Идэр
Шүтэн барилдлага:
Авахуй
Суудал: Уул

Энэ өдөр үхэр, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, хараал, жатхыг буцаах, газар лусын зан үйл хийх, өр барагдуулах, буг дарах, газрын ам бооход сайн. Ургаа мод таслах, байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд муу.

Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал өлзийтэй сайн.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН
2,273,004 /69.9%/	2,175,662 /66.9%/	1,040,412 32,0%
		125,447 /3,9%/

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	ЭДГЭРСЭН
8504 +112	13	8370

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол
Нийт: 521,230,984
Эдгэрсэн
Нийт: 491,824,498
Нас барсан
Нийт: 6,288,426



Цахим шууданд

"ЭХ ОРОН ГЭР БҮЛЭЭС ЭХТЭЙ" ӨДӨРЛӨГӨӨР ...



Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлал, Төв аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран "Эх орон гэр бүлээс эхтэй" гэр бүлийн өдөрлөг зохион байгууллаа. Жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдөр тохиодог "Олон улсын гэр бүлийн өдөр"-ийг тохиолдуулан гэр бүлийн үнэ цэн, харилцаа, эцэг, эхийн хариуцлага, үр хүүхдүүдийн хүмүүжил гэсэн сэдвүүдийн хүрээнд командлалын бүрэлдэхүүн гэр бүлийн хамт сургалтад хамрагдаж, нэгэн өдрийг үр дүнтэй өнгөрүүлэв.

Арга хэмжээний эхэнд Хуурай замын цэргийн командлагч хошууч генерал Б.Амгаланбаатар "Та бүхэнтэйгээ хоёр чухал үйл давхасан өдөр уулзаж байгаадаа баяртай байна. Нэгдүгээрт, өнөөдөр Ерөнхий цэргийн мэргэжлийн өдөр, хоёрдугаарт, маргааш "Олон улсын гэр бүлийн өдөр". Энэхүү тэмдэглэлт хоёр өдөр нь та бидэнд онцгой чухал учраас гэр бүлийн гишүүдээ урьж, уулзаж байгаа нь энэ. Хуурай замын цэргийн командлал захиргааны удирдлага бие даан хэрэгжүүлж эхэлснээс хойш нэг зүйлд онцгой анхаарсан нь алба хаагчдынхаа төлөвшил, гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн харилцаа, хүүхдийн хүмүүжил юм. Өнөөдөр цэргийн албанаас гадна тэдний хүмүүжил, төлөвшил, гэр бүлд онцгой анхаарах ёстой цаг үе ирсэн байна. Хоршиж анхаарах ёстой гэсэн үг. Тийм ч учраас 2020 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл,

хүүхэд, залуучууд, хөгжлийн газартай хамтын ажиллагааны гэрээ байгуулсан бөгөөд харьяа нэгтгэл, ангиуд ч өргөн хүрээнд хамтран ажиллаж байна" гэв. Тэрээр цааш нь "Хуурай замын цэргийн үйл ажиллагаа амжилттай байгаагийн ард Зэвсэгт хүчний бат бэх ар тал, ёс суртахууны үндэс суурь нь болсон гэр бүл, үр хүүхэд байдгийг баярын

"Гэр бүлийн харилцаа", "Дэлхийн зөн" олон улсын байгууллагын Төв аймаг дахь салбарын хөгжлийн чиглүүлэгч Ч.Уранчимэг "Эерэг хүмүүжлийн арга", "Монголын гэр бүлийн сайн сайхны төлөө нийгэмлэг"-ийн Төв аймаг дахь салбарын менежер Б.Отгонлхагва "Гэр бүл төлөвлөлт" сэдвээр тус тус сургалт явуулж, командлалын



энэ өдөр онцгойлон хэлэхийг хүсэж байна. Ерөнхий цэргийн мэргэжлийн өдөр бол амьдралынх нь үнэнч хань, амжилтынх нь өмөг түшиг болж, алдаа оноо бүрийнх нь ард сэтгэл догдлон байдаг ар гэрийнхэн та бүхний баярын өдөр юм" гээд өдөрлөгийг хамтран зохион байгуулсан Г.Отгонтуяа даргатай Төв аймгийн Гэр бүл, хүүхэд, хөгжлийн газрын хамт олонд талархал илэрхийлсэн юм.

Энэ үеэр аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн М.Анхчимэг

гэр бүлийнхний дунд хөгжөөнт тэмцээн зохион байгуулахад хошууч Ц.Ганбатын гэр бүл тэргүүлэв.

Мөн энэ өдөр тус командлалын Санхүүгийн хэлтсийн дарга, хурандаа Т.Анхухантан Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар "Цэргийн гавьяаны одон"-гоор шагнагдсаныг гардуулан өгч баяр хүргэсэн юм.

Өдөрлөгийн төгсгөлд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд ХЗЦК-ын байрлалд генерал, офицер, ахлагч нар гэр бүлийн хамт мод тарилаа.

ЦЭРГИЙН АЛБЫГ БИЕЭР ДҮЙЦҮҮЛЭН ХААГЧДЫН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙНА



Хэнтий аймгийн Засаг даргын А/235 дугаар захирамж, аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын 2022 оны Сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагчдын нэгдсэн сургалтыг 5 дугаар сарын 10-ны өдрөөс 14 хоногийн хугацаатайгаар Цагдаагийн газрын сургалтын төвд зохион байгуулж байна.

Тус цэргийн штабаас "Цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл" шатны 2 багц буюу 96 цаг болон "Тусгай үүргийн бэлтгэл" шатны 2 багц буюу 96 цагийн сургалтын

хөтөлбөрийг боловсруулан цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагчдад онол арга зүйн сургалт хичээл зааж байна. Мөн сургалтын үеэр суралцагчид Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүхийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд нэгдэж, 200 гаруй мод тарьж, 300 гаруй модны нүх ухаж суулгац суулгахад бэлэн болгож, Хэрлэн сумын ЗДТГ-т хүлээлгэн өгч ажиллалаа.

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗДТГ-ЫН ЦЭРГИЙН ШТАБ

"АМТАЛГААТ" ӨДӨРЛӨГ ҮНЭХЭЭР АМТТАЙ, СОНИРХОЛТОЙ БАЙЛАА



Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн захирагчийн баталсан тасаг, алба, салбар сурталчлах удирдамжийн дагуу Хүнсний алба 2022 оны 5 дугаар сарын 13-ны өдөр бие бүрэлдэхүүнд сурталчилгааны ажлыг зохион байгууллаа.

Аяны хүрээнд тогооч Б.Энхтуяа "Эрүүл тэнцвэржүүлсэн хооллолт ба амьдралын алтан гурвалжин" сэдвээр бие бүрэлдэхүүнд сонирхолтой лекц, ярилцлагыг өрнүүлж, цэргийн гал тогооны бие бүрэлдэхүүнээс "Амталгаат" хоолны өдөрлөгийг зохион байгуулж, азын сугалаа сугалуулж, гурван цэргийн алба хаагчийг баярлуулсан юм. Хоолны өдөрлөгөөр тэд ангийн бие бүрэлдэхүүнд таван нэр төрлийн хоёрдугаар хоол, гурван нэр төрлийн салат, зууш, бялуу, кекс, жүжлсэн үйлчилсэн нь үнэхээр амттай, бүтээлч, сонирхолтой байлаа. Мөн хугацаат цэргийн алба хаагчдын дунд "1 сая 1 минут" хөгжөөнт тэмцээнийг зохион байгуулж, дайчдын авхаалж самбаа, хурд хүчийг сорин нэг өдрийг баяр хөөртэйгөөр өнгөрүүлэв. Бүтээлч ажлын хүрээнд цэргийн гал тогооны мэдээллийн самбарыг шинэчлэн, хугацаат цэргийн алба хаагчдын хэрэгцээнд давуун маск оёж өглөө.

Ахлах дэслэгч Т.ДЭЛГЭРМАА

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 340 ДҮГЭЭР АНГИ "ТЭРБУМ МОД" ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНД НЭГДЭВ



Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигаар баталсан "Мод тарих үндэсний өдөр"-ийг тохиолдуулан Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийн хамт олон Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд нэгдлээ.

Тус ангийн байрлалд ногоон төгөл

бий болгох зорилгоор мод тарих ажлыг үе шаттайгаар 5 сарын 11-ний өдрөөс эхэлсэн бөгөөд уг ажлын хүрээнд нийт бие бүрэлдэхүүн бүрэн хамрагдаж, эхний ээлжийн гурван төрлийн 300 суулгацыг ийнхүү суулгасан юм.

Сэтгэл зүйч офицер, энгийн Д.УЯНГАА

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 284 ДҮГЭЭР АНГИ НОГООН ТӨГӨЛТӨЙ БОЛЛОО

Тус ангийн бие бүрэлдэхүүн Шинжлэх ухааны академи, Залуу эрдэмтдийн холбоотой хамтран Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнд ангийн төгөл байгуулж, улиас, монос, шар хуайс бүхий 101 орчим мод суулгалаа.

"Бүх нийтээр мод тарих өдөр"-ийг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Нэг тэрбум мод" үндэсний хөтөлбөрийн хүрээнд Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2021 оны 1/4641 дүгээр албан даалгаврын дагуу ангийн бие бүрэлдэхүүн ийнхүү байгалийн ашигт ургамлын үр, суулгацын нооц, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, орчны бохирдлыг бууруулах чиглэлийн үйл ажиллагаанд идэвх санаачилгатай оролцсон юм.

